



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 4/06

Хараат

「 Албан тушаалын тодорхойлолт батлах тухай 」

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.4 дэхь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн Зөвшөөрөл батлах тухай 42 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралт, Санхүүгийн албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэн төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйг чанд сахин мөрдөж ажиллахыг дээрх эрх бүхий албан хтушаалтнуудад үүрэг болгосугай.

3."Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн хэрэгжилтийг ханган Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг төрийн захиргааны албан хаагчдад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БУДЖАВ

482001012